

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2022 оны 08 сарын 10-ны өдөр

Дугаар УКД - 12/2022

Сайншанд сум

НЭГ.УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол Улсын Дорноговь аймаг, Сайншанд суманд байршилтай “Халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга барих” ажилд Дорноговь аймаг /нийслэл/-ийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн A/515 дугаар шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

ХОЁР.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо **2021.10.01**, дугаар **БАЗ-ОНХС-БУ-14/2021**;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: **ХАТ-10/20**;

2.3. Захиалагч: /Хуулийн этгээдийн хувьд/: Аймгийн Засаг даргын Тамгын газар оноосон нэр, **670001134** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг: Дорноговь аймаг /нийслэл/, Сайншанд сум /дүүрэг/, 3-р баг /хороо/, Нутгийн удирдлагын ордон байр /хашаа, хаалга/-ны дугаар, **70522656, 70522674** холбоо барих утас, цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Төгс Өнөд” ХХК хуулийн этгээдийн оноосон нэр, **611008007** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **БУ52-653/19** барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хаяг: Дорноговь аймаг, нийслэл Сайншанд сум, 3-р баг, **Мааньзав 4-6 тоот, 99109965** холбоо барих утас, цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: **байхгүй**.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Хатанбаатар” ХХК оноосон нэр, **9011039098** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **ЗТ11-451/19** зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот /нийслэл/, Баянгол /дүүрэг/, 2-р баг /хороо/, Сөүлийн гудамж **45/4 601** тоот ашаа, /хаалга/-ны дугаар, **77228888** холбоо барих утас, цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Аймгийн Нэгдсэн эмнэлэг оноосон нэр, **670001068** улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг: Дорноговь аймаг /нийслэл/, Сайншанд сум /дүүрэг/, 2-р баг /хороо/, Нэгдсэн эмнэлгийн байр /хашаа, хаалга/-ны дугаар, **70522382, 96646886** холбоо барих утас, цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга нь тэнхлэгээрээ 12.88x15м хэмжээтэй, даацын тоосгон ханатай, цутгамал төмөр бетон хүчилт бүхий 1 давхар барилга болон 20м3 хэмжээ бүхий анхдагч цэвэрлэх байгууламжийн хамт.

ГУРАВ. ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

-Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

3.1. Энэхүү дунд төвөгшилтэй ангиллын Халдвартын эмнэлэг зориулалттай барилга байгууламж, холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсондой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 5 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а). барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;


в). барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэл, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох..... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын Халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

КОМИССЫН ДАРГА:



НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

З.Ч. /Б.ЦЭНД-АЮУШ/
Аймгийн ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

***Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнасан хавсралтын хамт хүчинтэй.

---00---

1
**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

№ *ХТ-10/2022*

Сайншанд сум

Сайншанд суманд Халдвартын эмнэлгийн барилга барих болон Халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажлуудыг ашиглалтад оруулах комиссын хурлыг 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 14:10 цагт тус барилгын танхимд хуралдав.

Хуралд оролцсон нь:

Ц.Баярмаа /Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/
Ч.Чулуунцэцэг /Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч/
Л.Бямбатуяа /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ЭАХХХУАБайцаагч/
Н.Гарамжав /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ЭХХХХУАБайцаагч/
С.Ган-оргил /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын БТХУАБайцаагч/
А.Билгүүн /Аймгийн Онцгой байдлын газрын ГТУХАБайцаагч, Ахлах дэслэгч/
Б.Цэнд-Аюуш /Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн/
Э.Нандинцэцэг /Аймгийн ГХБХБГ-ын ахлах мэргэжилтэн/
Ч.Түвшинжаргал /МХС ТӨХК-ийн Дорноговь аймаг дахь салбарын кабель шугамын инженер/
М.Лхагвасүрэн /БЗӨБЦТС ТӨХК-ийн Дорноговь салбарын засварын инженер/
Э.Эрдэнэбаяр /"Чандмань-Илч" ХХК-ийн Горим тооцооны инженер/
Ү.Энхбаяр /Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/
П.Цэндсүрэн /Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэмжих үйлчилгээний албаны дарга/
Р.Батсэргэлэн /"Хатанбаатар" ХХК-ийн зургийн ерөнхий инженер/
Б.Алтан-Оргил /"Хатанбаатар" ХХК-ийн инженер/
Г.Отгонтуяа /"Хатанбаатар" ХХК-ийн инженер/
Б.Амарсайхан /"Хатанбаатар" ХХК-ийн инженер/
Д.Дагвадорж /"Хатанбаатар" ХХК-ийн инженер/
Х.Өнөбаяр /"Төгс өнөд" ХХК-ийн захирал/
Э.Болдхангай /"Төгс өнөд" ХХК-ийн инженер/

Хурлыг комиссын дарга Ц.Баярмаа нээж, Монгол улсын Засгын газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны А/515 дугаар захирамжаар томилогдсон барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сайншанд суманд Халдвартын эмнэлгийн барилга барих болон Халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж барих ажлуудыг комиссоор шалгасан тухай.

СОНССОН НЬ:

Л.Бямбатуяа:

1. Салхивчний агаар оруулах сараалж зурагт 7 байхад 6-г хийсэн байна. Ил далд ажлын актыг тодорхой болгох
2. Сүрьеэ, евчтөний хагас бүтэн вестибюльд агаар гаргах механик сэнсгүй, серөг даралт үүсгэхгүй болгох
3. Угаалтуурын тосгууртай тулгаж байрлуулсаныг өөрчлөх
4. Зарим өрөөний плитаны засвар хийсэн чигжээсийг сайжруулах, хагархайг солих
5. Поддоны шохойдсон хэсгийг будах
6. Хаалганы завсарыг чигжих, цавуу наалдсаныг угаах
7. Амьсгалын замын хэсгийн шалны плитаны дутууг гүйцээх
8. Шалны хулдаасны ирмэг завсарыг наах
9. Хаалганы жийргэвч резинийг унахгүйгээр тогтоох
10. 2 давхарын шалны түвшин алдаж босго үүссэн хэсгийг тэгшлэх
11. Зарим агааржуулалтын решотка дутууг гүйцээх
12. Орохыг хориглоно тэмдэглэгээтэй гэрэлтүүлгийн тоноглолыг угсралт
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний тоноглол хийх
14. Ариун цэврийн /угаалгын/ өрөөнд халуун, хүйтэн усны шугамын угсралтыг ил хийснээс шалтгаалж шүршүүрийн холигчийг хананаас хэт хөндий зайдай угсралтад байгааг засварлах
15. Үндны усыг шинжилгээнд хамруулах
16. Цахилгааны утасны үүрийг гүйцээх
17. Дутуу бусад эвдэрсэн угаалтуурыг засах
18. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гадна налуу замыг тэргэнцэртэй хүн явах нөхцлийг бүрдүүлэх
19. Угаалгын барилгын дотор заслал дутууг гүйцээх, сайжруулах
20. Урьдчилсан цэвэрлэх байгууламжийн хлор хийх люкны амсарт сараалж хийж аюулгүй байдлыг хангах
21. Хлор дозлогч хийх
22. Төвлөрсөн шугамд нийлэх хэсэгт дээж авах цорго хийх
23. Заслын материалын болон цэвэр усны шугамын чанарын сертификат актад хавсаргах

С.Ган-Оргил:

1. Хаалгануудын амалгаа ханыг янзлах нөхөх, наалдсан эмульс, замаскийг бүрэн арилгах, резин зеөлөвчийг нааж бэхлэх
2. Нүүрэн талын бетон хаяавч суулт өгж зайд завсар үүссэнийг нөхөх
3. Хагарсан, дутуу нөхөгдсөн плитаг солих
4. Цонхны усны хаялага дутууг нөхөж суурилуулах
5. Ариун цэврийн өрөөнүүдийн хоолой шугамыг цэвэр далдлах, эмульс будаг, замаскийг бүрэн арилгах
6. Гарах үүдний саравчны дээд хэсгийн парпет тоосгыг бүрэн шавардах далдлах
7. Угаалга ариутгалын барилгын розетка хоорондын замаскыг янзлах, шалны налууг янзлах, ус зайлцуулах хоолойн түвшинг тааруулж угсралт
8. Эмнэлгийн барилгын сэргийж ховхорсон наалт салсан хулдаасыг бэхлэх

- Дутуу хийгдсэн гэрэлүүдийг солих бүрдүүлэх, халаах хэрэгсэлд наалдсан замаск, эмульс арилгах, цэвэрлэгээг бүрэн гүйцэтгэж сайжруулах

Н.Гарамжав:

- ТП-33 дэд өртөөний 0.4кВ талд ШО угсарч суурилуулах
- 0.4кВ-ын ерөнхий рубильникийг 630А АВР-аар солих
- Генераторыг суурилуулах
- Цахилгааны самбаруудад схем, нэр хаяг, вирк хийж өгөх

Ч.Чулуунцэцэг:

Халдвартын эмнэлэг, халдвартын эмнэлгийн угаалга, ариутгалын барилга угсралтын ажлын зураг төслийн баримт бичгийг үзэж танилцаад дараах үүргийг өгч байна.

- Барилгын зураг төслийн баримт бичгүүдийг объект тус бүрээр ангилж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх
- Барилгын ил далд ажлын актыг бүрэн бичиж баталгаажуулах
- Ил далд ажлын гэрэл зурагт хаяг тайлбар бичих
- Барилгын ажил гүйцэтгэсэн тэмдэглэлийг бүрэн бичиж баталгаажуулах
- Ашигласан материалын гарал үүслийн гэрчилгээ, сертификатыг бүрдүүлэх, гадаад хэл дээр байгааг баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг хүснэгтээр гаргаж, баталгаажуулах
- Төрийн архивт барилга объектын зураг төслийг эх баримтыг хүлээлгэн өгөх
- Гүйцэтгэлийн болон өөрчлөлтийн зураг гаргаж баталгаажуулах

А.Билгүүн:

- Хөөсөнцөр дулаалгын галд тэсвэржилтийн дүгнэлт гаргуулах
- Чиглэл заасан EXIT тэмдэг оновчтой газар байрлуулах
- Галын анхан шатны багаж зэвсэг нэмж MNS5566:2020 стандартын дагуу байрлуулах
- Аваарын гэрэлтүүлэг оновчтой газар байрлуулах
- Галын дохиоллын системийг самбар хаягжуулах
- Аянга хүлээн авагч хийх
- Галын самбарт хоолой хошуу холбох, мөн шил хийж хаягжуулах

Ц.Баярмаа, Э.Нандинцэцэг:

Халдвартын эмнэлэг:

- Ариун цэврийн өрөөнүүдийн хаалганы дээд хэсэгт наасан плита хагарч гэмтснийг солих, зузаан замасктай хагарал өгсөн байгааг жигдэлж, хананы плитагаар гүйцээх
- Угаалтуурын сипон хоолой нь усан хаалтгүй байгаа тул бүгдийг ариун цэврийн шаардлага хангасан усан хаалт бүхий сипоноор солих
- Бохирын үнэр гаргагч яндангууд нь дээврийн парпетны хананаас доош шахтанд байрлаагүй дулаалгагүй байгаа тул үнэр татахгүй байх эрсдэлтэй. Иймд шахтыг бүрэн тоосгоор өрж, шахтны түвшингийн хэмжээгээр хоолойн дулаалгыг хийж өгөх
- Эмнэлгийн цонхны усны гадна хаялага темэр дутуу байгааг гүйцээх
- Дээврийн хар цаас хөндийрч байсан хэсгүүдийг цоolon хийг гаргаж мастикаар дүүргэсэн байгаа дээр нөхөөс хар цаасыг сайтар битүүмж сайтайгаар нааж өгөх

6. Ариун цэврийн өрөөнүүдийн хана шалны уулзвар, булангуудын ирмэг буланг цэвэр нямбай силинкondож өгөх, хөдөлгөөнтэй байгаа холигчуудыг бэхлэх
7. Сантехникийн шугаманд зориулан хананд гаргасан нүхийг цэвэр үзэмжтэй нөхөж засварлах
8. Поддонуудад хаалт хөшиг хийх
9. Бүх өрөөнүүдийн хаалганы зеөлевч резинүүдийг нааж унахааргүй болгож бэхлэх
10. Саравчны дээврийн ус хаях уклоныг хоолой руу чиглүүлэн засварлах /барилгын хана талаас өндөрлөгөө хийх/
11. 2 дугаар давхарт дээвэр лүү гарсан салхижуулалт, бохирын хоолойнууд таазаар гарсанг чижиж цэвэр үзэмжтэй зайд завсрыг бөглөх, мөн аж ахуйн өрөөнүүдийн шал хананы уулзваруудыг цэвэрхэн силикондож өгөх/
12. Хөндийрсэн шалны хөвөөг наах
13. Бүх чижээс хийсэн булан ирмэгийн гадаргууг угааж цэвэрлэхэд ховхорч унахгүй эдэлгээ даахуйц болгох /шал, поддоны хөвөө г.м./
14. Узелийн өрөөний шугам хоолойд ус чийгнээс хамгаалсан түрхлэг түрхэж дулаалга хийж өнгийн туусаар ороох. Узелийн өрөөний дотор заслалын ажлыг гүйцэтгэхдээ шугам хоолой, тоноглолуудыг будаг, эмульс асгаж халтартуулсныг бүрэн цэвэрлэх
15. Хэвтэн эмчлэх тасаг болон өрөөнүүдэд цахилгаан, холбооны разетка хоорондох зааг хэсгийн заслалыг цэвэр үзэмжтэй хийх
16. Зарим өрөөнүүдийн цонх цанталт үүсч байгааг засварлах
17. Эмнэлгийн зориулалтай ханын барилгын бариулыг хийх

Халдвартын эмнэлгийн угаалга ариутгалын барилга, цэвэрлэх байгууламж:

1. Шахтанд агааржуулах болон бохирын үнэр гаргагч хоолойнууд хамтдаа угсралдсан тул хамар хана үүсгэн тусгаарлаж өгөх
2. Дээвэрт гарах гадна төмөр шатны дор хөлөөр авирах хэсэгт төмөр хамгаалалт хийж фасадыг хамгаалж өгөх
3. Агааржуулалтын хоолой ухагдаагүй гипсэн таазыг ухаж салхивчийн торыг байрлуулах
4. Дутуу угаалтуур тосгуурыг байрлуулах
5. Шаланд гарсан бохирын зайлцуулах трапны түвшинг тааруулж засварлах
6. Душны поддоны хана хэсэгт гарсан зайд завсарыг дүүргэж засварлах
7. Урьдчилсан цэвэрлэх байгууламжийн ариутгалын барилгын шалны люкэнд сараалж тор хийж өгөх
8. Урьдчилсан цэвэрлэх байгууламжийн үзлэгийн шатыг зэврэлтээс хамгаалж будах
9. Халдвартын эмнэлгийн урд байрлах БҮХ-ын түвшинг газрын түвшинтэй ижил болгож намсгах
10. Урьдчилсан цэвэрлэх байгууламжийн хучаас шороон даланг багасгаж нягтруулга хийх

Б.Цэнд-Аюуш:

1. Барилга угсралтын ажлын бичиг баримтын иж бүрдлийг цахим файл болгон аймгийн ЗДТГ-т хүлээлгэн өгөх
2. БХТ-ийн норм, нормчлолын сангийн үнийг дансанд тушааж баримт өгөх
3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламжийг оруулах

Ч.Түвшинжаргал:

1. Гадна холбоожуулалтын тавцан таг хүртэл сайтар нягтруулж булах
2. Гадна холбооны дотор серверийн рак хүртэлх дамжилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэх

3. Дулааны өрөө рүү орсон кабелийг дамжилтын далдлагчаар оруулж шугамтай хамт гарсан хэсгийг тусгаарлаж гаргах
4. Дотор монтажуудыг бүрэн холболт хийж хаягжуулах, хэмжилтийн акт үйлдэх
5. Ариутгалын хэсгийн дотор дамжилтыг нэмж хийх
6. Худгийг цэвэрлэж шаллах

М.Лхагвасүрэн:

1. ТП-33-т Зш ШО суурилуулах ажил хийгдээгүй
2. 0.4кВ ерөнхий рубильникийг /630A/ АВР-аар залгах, таслах автомат суурилуулах
3. 0.4кВ оруулгын кабель шугамыг кадастрт оруулж эргэлтийн цэгийг тэмдэглэх
4. 0.4кВ щитнээс тэжээлтэй кабель шугаманд нэр хаяг бичиглэл хийх
5. Анхааруулах плакат нааж суурилуулах
6. Эзэмшилийн заагийг тодруулж шаардлагатай газруудад ТП-33-д тоолуур суурилуулах
7. 0.4кВ кабельд муфтыг хийх
8. Нөөц эх үүсвэр болон дизель генераторыг байрлуулж холболт хийх

Э.Эрдэнэбаяр:

1. Гадна шугам сүлжээний трасс өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн зураг гаргаж өгөх
 2. Бохир усны босоо шугаманд үзлэгийн трап суурилуулах
 3. Дулааны худагт цэвэрлэгээ хийх, шат хийх
 4. Узелийн өрөөний шугам сүлжээг будах, схем зураг тайлбар байрлуулах
 5. Гадна болон дотор дулаан, цэвэр бохир усны ажилд акт хийх
 6. Ариутгалын барилгын халаах хэрэгслийн үзүүлэлт бичиг баримт гарган зурагтай тулгах
 7. Бохир усны худаг дотор шавардлага хийж, засварлах
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Ү.Энхбаяр:

1. Хагарсан цонхыг шинэчлэх
2. Цөмөрсөн хаалгыг солих
3. Цахилгааны нөөц эх үүсгэвэр генераторыг суурилуулах
4. Халуун усны бойлерыг холбож ажиллагаанд оруулах
5. Орохыг хориглоно тэмдэглэгээг суурилуулах
6. Шатны ойролцоо ханын шавардлага толигор бус
7. Өвчтөний орны дэргэдэх гэрэл хэт дээр байрлуулсан
8. Тогны розеткууд доор байрласан.
9. Гадна талбайн тохижилт, шороог тэгшлээгүй
10. Угаалгын өрөөний тааз гипсэн хавтангаар хийгдсэн нь ашиглалтын явцад шаардлага хангахааргүй байна.
11. Хаалганууд вакуумдаж хаагддаггүй.
12. Хулдаас бааран өнгөтэй
13. Коридорын шалны плита хэт гөлгөр гадаргуутай халтирах эрсдэлтэй
14. Галын хайрцаг шилгүй, холболт дутуу
15. Душ угаалгын өрөөний шалны ирмэг хурц засварлах
16. Өвчтөн барих ханын бариулгүй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан бариулыг хийх
17. Үүд хаалганы зеөлөвч наалтгүй
18. Плат, коридорын шалны түвшин жигд бус, тэргэнцэртэй өвчтөн ороход саадтай.

П.Цэндсүрэн:

Халдвартын эмнэлэг:

1. Аваарын цахилгаан үүсгүүрийг бэлэн болгож суурилуулах
2. Хэрэглээний халуун усны цахилгааныг холбож хэвийн ажиллагааг хангаж өгөх
3. Гадна бохир усны цэвэрлэх байгууламжийг авторын өгсөн зөвлөмжийн дагуу болгож өгөх
4. Дотор голын гидрантын иж бүрдэл хангагдаагүй
5. 1, 2 дугаар давхарын коридорын ханын бариул хийх
6. Угаалга, ариутгалын барилгад угаалгын машин суурилуулах, өрөөний трапыг шалны түвшинд болгох

Д.Дагвасурэн, Р.Батсэргэлэн:

Ус хангамжийн ариутгах татуурга, дотор систем:

1. Ариутгах татуургын босоо шугаманд шалгах тагны харалдаа үйлчилгээ хийх зориулалтын таг гаргах /нормын дагуу/
2. Ариун цэврийн өрөөний холболтуудыг дахин шалгаж угсралтыг гүйцээх
3. Узелийн өрөөнд ус хангамж, халуун усны шугамыг дулаалах
4. Дээврийн ариутгах татуургын шугамыг дээврийн прапеднаас дээш гаргаж дулаалж, малгайвч өмсгөх шаардлагатай
5. Галын краны шилэн нүүр, таних тэмдэглэгээг хийх

Гадна ариутгах татуурга, ус хангамжийн систем:

1. Ариутгах татуургын гаргалгааг зургаас өөрчлөн хийсэн байна. Гаргалгааны худгийг хөрснөөс дээш 5-10см байх нормтой. Хөрснөөс дээш хэт өндөрт угсарсан байна.
2. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг зургаас өөрчлөн угсарсан байна. Зургийн дагуу өөрчилж угсрах /үйлчилгээ хийх худгийн таг хөрснөөс 5-10см байх/
3. Хлораторын өрөөнд 2 ширхэг сав, шугам хаалтыг зургийн дагуу угсрах
4. Гадна ариутгах татуургын худагт зургийн дагуу 2 дахь таг дулаалга хийх
5. Гадна ариутгах татуургын шугам, цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэлийн зургийг хийж зохиогчтой зөвшилцөх шаардлагатай
6. Хлорын уусмалын өрөөнд тагны дор давхар торон таг байрлуулах

Барилга, архитектор:

1. Гадна тохижилтын ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгэх
2. Явган хүний замын өргөнийг нормын дагуу хийх
3. Ногоон байгууламжийн ажлыг бүрэн хийх
4. Ил далд ажлын акт бүрдүүлэх, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Б.Амарсайхан:

1. Дизель генераторыг зургийн дагуу тавьж тоноглох
2. Гадна цахилгааны угсралтыг гүйцээж тоноглох, байнгын хүчдэлд холбох /ШО-70/
3. Эмнэлэг, аж ахуйн блок, цэвэрлэх байгууламжид дутуу байгаа зүйлсийг зургийн дагуу гүйцээх /гэрэлтүүлэг, самбарт хаягжуулалт, аянгын тоноглолыг зэврэлтээс хамгаалсан зориулалтын будгаар будах/
4. Гадна цахилгааны кабелийн трассыг бага зэрэг өөрчлөж татсаныг гүйцэтгэлийн зургаар оруулах, мэдээллийн санд оруулах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг 14 хоногт багтаан бүрэн биелүүлж, үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлсний дараа байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв. Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 19 цаг 30 минутанд хаав.

Саналын хуудсыг хавсаргаа.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

КОМИССЫН ДАРГА:

Н.Доржийн

Ц.БАЯРМАА

/ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга/

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

З.Ч.Чимб

Б.ЦЭНД-АЮУШ

/Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн/